
Хариуцлагатай Уул Уурхайн Индекс 2018

Талархал

Хариуцлагатай Уул Уурхайн Сан нь 2018 оны Индексийг боловсруулахад үнэтэй хувь нэмрээ оруулсан байгууллага, хувь хүмүүст талархсанаа илэрхийлж байна. Хүн бүрийн нэрийг энд дурдах боломжгүй хэдий ч манай байгууллага та бүгдийн үзүүлсэн үнэлж баршгүй зөвлөгөө, мэргэжлийн зөвлөмж болон өгсөн урмыг тань өндрөөр үнэлж байна.

Санхүүжүүлэгчид

Swiss State Secretariat for Economic Affairs
The Netherlands Ministry of Foreign Affairs
Omidyar Network Fund
Wyss Charitable Endowment
Good Energies Foundation
Cordaid
PeaceNexus Foundation

Хариуцлагатай Уул Уурхайн Индексийн Хөндлөнгийн Хяналтын Комисс

Sonia Balcazar
Fritz Brugger
Li Li
Glen Mpufane
Lisa Sachs
Prabindra Shakya
Ingrid Watson
Luc Zandvliet

Хариуцлагатай Уул Уурхайн Индексийн Хөндлөнгийн Шинжээчдийн Баг

Britt Banks
Peter Colley
Afshin Mehrpouya

Бусад Экспертүүд болон Түншүүд

Access to Medicine Index
Access to Nutrition Index
Access to Seeds Index
RMF Advisory Council
SNL Global
Solaron
Magnus Ericsson
Philippe Spicher

Хариуцлагатай Уул Уурхайн Индексийн техник эдийн засгийн үндэслэл, дугуй ширээний болон олон нийтийн санал авах хэлэлцүүлэг

Индекс болон түүний техник эдийн засгийн үзүүлэлт, судалгааны арга зүйг боловсруулах явцад дугуй ширээний уулзалтуудад оролцон өөрсдийн үзэл бодлоо хуваалцсан болон олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр санал хүсэлтээ ирүүлсэн уул уурхайн нөлөөллийн бүсэд орших нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн нэгдлийн төлөөлөгчид, иргэний хөдөлгөөнүүд, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд, засгийн газрын байгууллагууд, уул уурхайн ассоциацууд болон компаниуд, олон талт оролцогчдын санаачилгууд, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, эксперт зөвлөхүүд болон бусад хувь хүмүүст талархсанаа илэрхийлж байна.

Хэвлэлийн эх бэлтгэсэн

Vizzuality
Omdat Ontwerp

Орчуулга хийсэн

Prime Production Ltd
China Dialogue

Хариуцлагатай Уул Уурхайн Индекс **2018**



Судалгааны Түнш



Агуулга

4	Оршил
6	ХУУИ-ийн үнэлгээний хүрээ
9	2018 оны ХУУИ-ийн үнэлгээний үе шатууд
10	2018 оны ХУУИ-д хамруулсан улс, компаниуд
12	Үндсэн ололтууд
14	Нийт үр дүн
18	 Эдийн засгийн хөгжил
20	 Бизнесийн ёс зүй
22	 Уурхайн ашиглалтын үе шат удирдлага
24	 Орон нутгийн сайн сайхан
26	 Ажиллах нөхцөл, орчин
28	 Байгаль орчны хариуцлага
30	Уурхай тус бүрийн үнэлгээний үр дүн
32	Ажигласан зүйлс

Оршил

ХУУИ-ийн үнэлгээ

Хариуцлагатай Уул Уурхайн Сан (ХУУС) нь дэлхий даяарх олон байгууллага хувь хүмүүсийн адил уул уурхайн хариуцлагатай хөгжлийг дэмжихийн сацуу уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч улс орнуудад тулгардаг нийгэм, байгаль орчны нөлөөллийн олон тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулдаг.

Бага болон дундаж орлоготой улсуудын хувьд уул уурхай нь ДНБ болон экспортын чухал хэсэг юм.¹ Өргөн хүрээний, алс хэтийн боломжийг нь авч үзвэл уул уурхай нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад хүрэхэд түлхэц өгөх боломжтой. Хэдий тийм боловч нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг нэг удаа ашиглаад өнгөрөх нь эдийн засгийн хөгжлийг хурдасгаж чадахгүй байх нь түгээмэл төдийгүй², уул уурхайн үйл ажиллагаа хүн болон байгаль орчинд урт хугацааны сөрөг үр дагавар авчирсан тохиолдол хэтэрхий олон байгаа билээ.

Хариуцлагатай Уул Уурхайн Индекс (ХУУИ) нь эрдэс болон металл олборлолт нь тухайн түүхий эд үйлдвэрлэгч орны эдийн засагт үр ашгаа өгч, хүмүүсийн амьдралыг сайжруулж мөн байгаль орчныг нь хүндэтгэхийн зэрэгцээ компаниуд шударга бөгөөд хэрэгжих боломжтой байдлаар ашиг хүртэх ёстой хэмээх зарчмыг дэмждэг.

Энэхүү үзэл санаанд үндэслэж ХУУИ нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг томоохон уул уурхайн компаниудын эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын (ЭЗБОНЗ) асуудлуудад холбогдох бодлого, үйл ажиллагааг ил тодоор үнэлж, үлгэр жишээ авч суралцах замаар хариуцлагатай уул уурхайн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэхийг зорьдог.

ХУУИ нь уул уурхайн томоохон компаниудад нийгмийн зүгээс тавьж буй зүй ёсны хүлээлт, шаардлагын үүднээс компаниудыг үнэлж, эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг шийдвэрлэхдээ компанийн бүх үйл ажиллагаа болон төслийн үе шат бүрийг хамруулан системтэйгээр хандсан эсэхийг шалгаж үздэг.

Энэхүү анхдугаар буюу 2018 оны ХУУИ нь 16 улсын 30 компанийг хамарсан бөгөөд үүнд төрийн өмчит, хувийн болон хувьцаат компаниуд багтсан. Эдгээр компаниуд нь 40 гаруй улсын 700 гаруй уурхайд үйл ажиллагаа явуулдаг ба үнэлгээ нь газрын тос, байгалийн хийн салбараас бусад ихэнх уул уурхайн түүхий эдийг хамарсан. Индекс нь холбогдох компанийн нийт үйл ажиллагаанд голчлон анхаарлаа хандуулахын зэрэгцээ тодорхой уурхайн талбар дахь дүр зургийг харуулахын тулд 127 уурхайн талбарын үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцсан.

ХУУИ-ийн үнэлгээ нь эдгээр компаниуд болон уурхайн талбарт холбогдох олон нийтэд нээлттэй мэдээлэлд суурилсан. Нотолгоонд тулгуурласан үнэлгээ болохын хувьд ХУУИ нь компаниуд хариуцлагатай бодлого, арга ажиллагааг нэвтрүүлсэн хэмээн мэдэгдэх төдий бус бодитоор хэрэгжүүлж байгаагаа ямар хэмжээнд батлан харуулж чадаж буйг үнэлэн дүгнэсэн.

1 Ericsson, M. and Löf, O. (2017). *Mining's contribution to low- and middle-income economies*. United Nations University WIDER Working Paper 2017/148.

2 Lange, G-M., Wodon, Q. and Carey, K. eds. (2018). *The Changing Wealth of Nations 2018: Building a Sustainable Future*. Washington, DC: World Bank.

Дүгнэлт

Өнгөрсөн хэдэн арван жилд уул уурхайн олон том компаниуд эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын (ЭЗБОНЗ) асуудлуудыг шийдвэрлэхэд томоохон ахиц гаргасан ба энэ нь хариуцлагатай уул уурхайн санаачилгын хүрээнд олон талын оролцогчид, түншүүдийг татан оролцуулж шинэлэг үйл ажиллагааг нэвтрүүлснээр илэрч байна. Гэхдээ нийгмийн зүгээс зохих ёсоор тавьж байгаа шаардлагуудыг компаниуд системтэй, үр нөлөөтэй авч үзэж, шийдвэрлэж байна гэдгийг нотлох хэцүү хэвээр байгааг ХУУИ-ын үр дүн харуулж байна.

Компани тус бүрд холбогдох үр дүн нь тэд илүү ихийг хийх шаардлагатайг харуулж байгаа ч зохих үр дүнг гаргах боломжтой гэдгийг илэрхийлж байгаагаараа эерэг зүйл юм. 2018 оны ХУУИ-ийн үр дүн нь компаниуд бүх үзүүлэлтийн хувьд хамгийн дээд талын оноог авч байж хүрч болох нийт дүнгийн 70%-д хүрэх боломжтой гэдгийг харуулж байна. Үүнээс одоогийн байгаа сайн туршлагыг бүх компаниуд системтэйгээр хэрэгжүүлбэл нийгмийн хүлээлтэд хүрэхүйц түвшинд дөхөх боломжтой гэсэн дүгнэлт хийж болно.

Тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хариуцлагатай бодлого зохицуулалт боловсруулж буйгаа нэлээд хэдэн компани батлан харуулсан. Үнэлгээнд хамрагдсан нийт 30 компанийн 19 нь ХУУИ-ийн хамрах сэдвийн хүрээнд багадаа нэг удаа өндөр үзүүлэлт гаргасан нь үйл ажиллагааны гүйцэтгэл компанийн хэмжээ, олборлох бүтээгдэхүүн хийгээд газар зүйн байршлаас хамаардаггүй болохыг харуулж байгаа юм.

ХУУИ нь шилдэг туршлагыг хэрэгжүүлэхэд бодлоготой хандан, шинийг санаачилж, энэхүү тайланд багтсан эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын асуудлуудыг шийдвэрлэхэд гаргасан олон компаниудын хүчин чармайлтыг сайшааж байна.

2018 оны ХУУИ-ийг бүх оролцогчдод зориулж үнэ төлбөргүйгээр нийтэлсэн ба илүү олон компаниуд хариуцлагатай арга ажиллагааг нэвтрүүлэхэд суралцаж, урам зориг авна гэж итгэж байна.

Тайлан

Энэхүү тайлан нь 2018 оны ХУУИ-ийн гол үр дүнг тоймлон харуулна. 2018 оны ХУУИ-ийн үр дүнг бүхэлд нь мөн Индонезийн бахаса, Хятад, Франц, Орос болон Испани хэл дээрх орчуулгыг www.responsibleminingindex.org цахим хуудсаар орж үзэх боломжтой.

ХУУИ-ийн үнэлгээний хүрээ

ХУУИ нь хариуцлагатай уул уурхайд холбогдох эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын (ЭЗБОНЗ) өргөн хүрээний асуудлуудыг багтаана. ХУУИ нь уул уурхайн томоохон компаниудад нийгмийн зүгээс тавьж буй зүй ёсны хүлээлт, шаардлагын үүднээс компаниудыг үнэлж, ЭЗБОНЗ-ийн асуудлуудыг шийдвэрлэхдээ компанийн бүх үйл ажиллагаа болон төслийн үе шат бүрийг хамруулан системтэйгээр хандсан эсэхийг шалгаж үздэг.

Индекс нь зургаан үндсэн сэдэвт төвлөрсөн:

- Эдийн засгийн хөгжил: Эрдэс баялаг үйлдвэрлэгч улсын үндэсний хэмжээний нийгэм-эдийн засгийн хөгжилд компаниуд хэрхэн хувь нэмэр оруулж байгаа;
- Бизнесийн ёс зүй: ёс зүй, сайн засаглалыг бэхжүүлэх үүрэг амлалтаа хэрхэн нотолж байгаа;
- Уурхайн ашиглалтын үе шат удирдлага: Компаниуд үйл ажиллагааныхаа нөлөөллийг уурхайн үе шат бүрд хэрхэн анхаарч зохицуулж байна, мөн уурхай хаагдсаны дараах нөхцөл байдлын үнэлгээ, төлөвлөгөөг төслийн эхний шатуудад хийж байгаа эсэх;
- Орон нутгийн сайн сайхан: компаниуд нутгийн иргэдтэй хэрхэн харилцаж, орон нутаг дахь нийгэм-эдийн засгийн нөлөөг хэрхэн зохицуулж байна;
- Хөдөлмөрийн нөхцөл: компаниуд эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлийг хэрхэн хангаж, ажилчдын эрхийг хүндэтгэж, ёс зүйтэй хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлж байна вэ;
- Байгаль орчны хариуцлага: компаниуд байгаль орчны нөлөөллөө хэрхэн системтэй, хамтарсан болон нээлттэй байдлаар үнэлж, зохицуулж байна.

ХУУИ нь эдгээр сэдвийн хүрээнд компани бүрд хийсэн 73 үзүүлэлтийн үнэлгээг агуулна.

Үүний дээр индикатор тус бүрийг үнэлгээний гурван бүлэгт багтааж авч үзсэн:

- Үүрэг амлалт хүлээсэн байдлыг үнэлэх индикаторт компани нь: (i) тодорхой нэг асуудлыг шийдвэрлэх албан ёсны үүрэг амлалт хүлээсэн; (ii) түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд үүрэг, хариуцлагыг оноож өгсөн; (iii) үүрэг амлалтаа ажил хэрэг болгохын тулд санхүү болон хүний нөөцөөр хангасан;
- Үйлдэл болгосон байдлыг үнэлэх индикатор нь компаниуд тодорхой асуудлыг шийдвэрлэх арга замаа тогтолцооны түвшинд тодорхойлж, үйл ажиллагааныхаа голлох чиглэлүүдийг ил тод болгосон;
- Үр нөлөөтэй байдлын индикатор нь компаниуд тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан явуулж буй үйл ажиллагаагаа эргэн хянаж, түүнийгээ мэдээлж мөн тухайн шийдвэрлэж буй асуудалд тогтмол ахиц дэвшил гарч буйг батлан харуулж байгаа эсэхийг үнэлнэ.

Компанид холбогдох индикаторуудаас гадна уурхайн түвшин дэх зургаан индикаторыг сонгогдсон 127 уурхайн талбарын түвшинд авч үзсэн. Эдгээр индикаторууд нь уурхайн талбар бүрийн үнэлгээг харуулах хэдий ч өгсөн оноо нь компанийн нийт үнэлгээний оноонд багтаагүй.

ХУУИ-ийн үнэлгээний хүрээ



ХУУИ-ийн үр дүнг хянан үзэхдээ дараахыг анхаарах нь зүйтэй юм:

- ХУУИ-ийн үнэлгээ нь нотолгоонд суурилсан болно. Энэ нь компаниуд энэхүү индексэд багтсан асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотой бодлого боловсруулсан болон түүнийгээ практик үйл ажиллагаандаа нэвтрүүлснээ нотлох ёстой гэсэн үг юм. Индексийн сэдэвчилсэн үзүүлэлтээр сул оноо авсан компаниудаас нотолгоо бага олдсон. Иймээс бага оноо гэдэг нь компанийн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх нь хангалтгүй байсны илрэл байж болох юм.
- ХУУИ нь компанийн хандлагын ерөнхий ерөнхий зураглалыг үзүүлж байгаа ба энэ нь үнэлгээ хийсэн үеийн (2017 оны дундуур) компанийн бодлого, үйл ажиллагааны талаарх тухайн үед олдож байсан хамгийн сүүлийн үеийн мэдээлэлд үндэслэсэн.
- ХУУИ-ийн үнэлгээний шалгууруудын ихэнх нь чанарт суурилсан. Энэ нь компаниудын оноо хоорондын багахан зөрөөнд ач холбогдол өгөх шаардлагагүй ба судалгаа шинжилгээний явцад үнэлгээний шалгуурыг хянуур боловсруулсан хэдий ч зарим нэг жижиг алдаа гарсан байхыг үгүйсгэхгүй.
- ХУУИ-ийн эрэмбэлэлт тус бүр компаниудын үйл ажиллагааг авч болох хамгийн өндөр оноонд (6 оноо) болон одоогийн шилдэг туршлагатай харьцуулан харуулсан ба үүний нэг жишээ нь тухайн нэг сэдэвт хамаарах индикаторуудын дагуу авсан хамгийн дээд онооны нийлбэрийг компанийн бүх үзүүлэлтийг харгалзан үзэж гаргасан.
- ХУУИ анх компаниудтай холбоотой зөрчлийн тоо болон түүнээс гарсан хор хохирлын хүнд хөнгөн байдалд суурилж компаниудын оноог буулгах боломжийг индексийн арга зүйд багтаасан байсан. Гэвч мэдээллийн олдцын харилцан адилгүй байдал болон бусад арга зүйн бэрхшээлүүдийн улмаас хүнд хэлбэрийн зөрчлүүдийн үр дүнг онооны системд нэгтгэхгүй байхаар шийдвэрлэсэн юм.

ХУУИ-н үнэлгээнд хамрагдаагүй зүйлс

ХУУИ нь уул уурхайн компанийн бодлого, үйл ажиллагааг өргөн хүрээнд авч үзэж үнэлдэг хэдий ч тэдний зарим үйлдэл, түүнийг тодорхойлох хүчин зүйлүүд нь индексийн хүрээ, аргачлалд багтах боломжгүй юм.

ХУУИ-ээр компаниуд үйл ажиллагаагаа цаашид байнга сайжруулж байгааг (“үр нөлөө” бүлгийн индикаторууд) авч үзэж байгаа боловч индекс нь ЭЗБОНЗ-ын асуудалд гарсан (эерэг, сөрөг) үр дагаврыг хэмжиж үзэх оролдлого хийдэггүй. Компанийн үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь ихээхэн төвөгтэй байгаагийн учир нь нэг компанийн үйл ажиллагааны үр дүн тухайн компанийн уурхайн талбарын тоо, үйлдвэрлэлийн үе шат, үйл ажиллагаа явуулж буй газрынх нь эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын нөхцөл байдлаас шалтгаалдаг тул хооронд нь шууд харьцуулах боломжгүй юм.

ХУУИ нь компаниуд өөрсдийн гаргасан аливаа шаардлага болон хэрэгжүүлэх процессоо компанийнхаа бүх үйл ажиллагаа болон түвшинд нэгдмэл, тууштай байдлаар хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлдэг. Хэдий тийм ч Индекс нь тухайн компанийн үйл ажиллагаа хоорондын ялгааг нарийвчлан судалдаггүй. Уурхайн талбарын үнэлгээ нь компанийн төслүүд хоорондын ялгааг харуулах нэг жишээ болох хэдий ч бүрэн хэмжээний үнэлгээ хийхэд илүү өргөн хүрээг хамарсан уурхайн талбарын тоо болон уурхайн түвшний индикаторууд шаардлагатайгаас гадна газар дээр нь бодит байдлыг тогтоох ёстой юм.

ХУУИ нь үйлдвэрлэгч улсын хууль журам, хөрөнгө оруулагчдын шаардлага, аливаа сайн дурын санаачилгын үндсэн дээр тогтоосон зорилт, стандарт гэх мэт гадаад хүчин зүйлүүд компанийн үйл ажиллагааны арга барилд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч уг нөлөөллийг хэмжихийг зориогүй.

2018 оны ХУУИ-ийн үнэлгээний үе шатууд

30 компани, 127 уурхайн талбарт холбогдох олон нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн эхний үнэлгээ хийгдсэн

Цуглуулсан мэдээллийг хянан үзэж, мөн нэмэлт мэдээлэл өгөх хүсэлтийг компаниудад тавьсан

Нийтэд нээлттэй болон компанийн зүгээс ирүүлсэн мэдээлэлд шинжилгээ хийсэн

Компаниудыг өөрсдийн тэргүүлэх туршлагаа санал болгохыг урьсан

ХУУИ нь тэргүүлэх туршлагуудыг тодорхойлон тогтоосон

ХУУИ нь компани болон уурхайн талбарын нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг цуглуулсан

Тухайн мэдээллийг баримтат, үнэн зөв эсэхийг хянаж үзэхийг компаниудаас хүссэн

ХУУИ-ийн хийсэн үнэлгээ ба өгсөн оноог хөндлөнгийн шинжээчид хянаж үзсэн

ХУУИ үнэлгээг эцэслэн гаргасан

Үнэлгээнд зориулж ашигласан эх сурвалжуудыг баталгаажуулан шалгахыг компаниудаас хүссэн


ХУУИ-ийн баг Индексийн тайланг нийтэлсэн




2018 оны ХУУИ-д хамруулсан улс, компаниуд

Үнэлгээнд хамрагдсан компаниуд

Anglo American
AngloGold Ashanti
Antofagasta
ArcelorMittal
Banpu
Barrick Gold Corp
BHP
Bumi Resources
Coal India
CODELCO
ERG
Evraz
Exxaro Resources
Freeport-McMoRan
Glencore
Gold Fields
Goldcorp
Grupo México
Industrias Peñoles
MMG
Navoi MMC
Newcrest Mining
Newmont Mining
NMDC
Rio Tinto
Teck Resources
UC RUSAL
Vale
Vedanta Resources
Zijin





- Компанийн төв захиргаа байрладаг улс
- Уул уурхайн бүтээгдэхүүн гаргагч улс
- Уурхайн-түвшний үнэлгээнд хамрагдсан уурхайн талбар

Үндсэн ололтууд

1 Хэрэгжүүлэх боломжтой байдал

Компани тус бүрээр нь авч үзвэл цаашид сайжруулах зүйл их байгаа хэдий ч ХУУИ-ээр үнэлгээ хийсэн компаниудыг нэгтгэн авч үзвэл хариуцлагатай уул уурхай нь бодит зорилт – түүнийг хэрэгжүүлэх боломжтой. 2018 оны ХУУИ-ийн үр дүн нь компани тус бүр бүх үзүүлэлтийн хувьд хамгийн дээд талын оноог авч байж хүрч болох нийт дүнгийн 70%-д хүрэх боломжтой гэдгийг харуулж байна. Үүнээс хэрэв бүх компаниуд хамгийн сайн туршлагыг системтэйгээр авч хэрэгжүүлбэл нийгмийн зүгээс хүлээж байгаа хүлээлтийг ямар нэг хэмжээгээр биелүүлэх боломжтой юм байна гэсэн гаргалгаа хийж болно.

2 Хариуцлагатай үйл ажиллагааны олон талт байдал

Нийт арван есөн компани Индексэд хамрах багадаа нэг сэдвийн хүрээнд хамгийн өндөр оноо авсан бөгөөд эдгээрээс арван компани нь хамгийн өндөр үзүүлэлт бүхий компанийн жагсаалтад багтаж байна. Олон компани тодорхой салбарт харьцангуй сайн үзүүлэлттэй байгаа төдийгүй хэрэгжилт тааруу байдаг асуудлуудыг шийдэх шилдэг туршлагууд илэрсний нэг нь уурхайн нөлөөлөлд өртдөг орон нутгийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулсан явдал юм. Ийнхүү олон тооны компани тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хариуцлагатай арга туршлагаа батлан харуулж буй нь үйл ажиллагааны гүйцэтгэл компанийн хэмжээ эсвэл олборлож буй түүхий эдийн төрөл, бүртгэгдсэн улс эсвэл олборлолт явуулж буй улсын байршил зэргээс төдийлөн шалтгаалдаггүй болохыг илэрхийлж байна.

3 Үүрэг амлалтуудаа бодитоор хэрэгжүүлэх шаардлага

Компаниудын дийлэнх олонх нь бизнесийн ёс зүй, хүний эрх, ажлын байрны эрүүл, аюулгүй байдал болон байгаль орчны нөлөөллийн менежмент гэх мэт асуудлаар бодлого боловсруулж, үүрэг амлалт өгсөн байна. Гэвч олон улсад бат бэх тогтон хэрэгжиж буй уг жишгийг даган үүрэг амлалт хүлээх компанийн тоо цөөн, чамлалттай хэвээр байна. Харин үүний нөгөө талд, цөөн тооны зарим компани өгсөн үүрэг амлалтаа үр дүнтэй ажил болгон биелүүлэх системтэй арга хэмжээ авч байгаагаа нотлон харуулж байгаа ч тухайн арга хэмжээнийхээ гүйцэтгэлийг хянан дүгнэж байгаа компани цөөхөн байна. Иймээс системтэй арга хэмжээ авч, түүнийхээ хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийж буйгаа батлах нотлох баримтгүй бол үүрэг амлалт өгөх нь хоосон дүр үзүүлсэн ажил мэт харагдаж болох юм.

4 Гарч буй дэвшилд саад болж буй сөрөг үр дагаврууд

Аливаа сөрөг нөлөөллийн тасралтгүй олон тохиолдлууд болон хэмжээ нь ЭЗБОНЗ-ийн асуудлуудыг үр ашигтай шийдвэрлэх талаар компаниудын гаргаж буй хөгжилд тушаа болж байна. Жишээ нь, компаниуд хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний эрхийг хүндэтгэх болон байгаль орчинд нөлөөлөх байдлын менежментийн асуудлыг шийдвэрлэх системтэй арга барилыг нэвтрүүлсэн нь илэрхий байх боловч үйлдвэрлэлийн ослоос үүдсэн ажилчдын нас баралт, байгаль орчны бохирдол, хүний эрхийн зөрчил (албадан нутагшуулах, газар булаах, нутгийн иргэдийн эсрэг хүч хэрэглэх гэх мэт) нь ХУУИ-ийн судалгаагаар илэрсэн хамгийн түгээмэл тохиолддог сөрөг нөлөөллүүд юм.

5 Ил тод байдлыг нэмэгдүүлэх гадаад хүчин зүйлс

Үндэсний, олон улсын болон олон талт оролцогчдын зүгээс тавьж буй тайлагнах шаардлагууд нь илүү ил тод нээлттэй мэдээллийг бий болгоход мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна. Тайлагнах үзүүлэлтээр илүү компаниудыг харвал тэд Глобал Тайлагналын Санаачилга (GRI), Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (EITI) Хүлэмжийн Хий Мэдээлэх Төсөл (Carbon Disclosure Project) болон хуулиар үүрэг болгосон зохицуулалтын хүрээнд тайлагнах тогтолцоог нэвтрүүлсэн байна. Харин уурхайн талбарын түвшинд хэрэгжиж буй үйл ажиллагаагаар эргэн хянаж түүнийгээ тайлагнаж буй тэргүүлэх туршлагууд нь хөрөнгө оруулагчид эсвэл олборлолт явуулж буй орны засгийн газраас тавьсан шаардлагуудын шууд үр дүн юм.

7 Уурхайн түвшний мэдээллийн хомс байдал

Уул уурхайн нөлөөлөлд өртдөг орон нутгийн иргэд, ажилчид болон бусад оролцогчдын эрх ашигт шууд хамаарах асуудлыг тайлагнаж буй уурхайн талбарын тоо тун бага байна. Үүнд уурхайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, орон нутгийн компаниудыг ханган нийлүүлэгчээр татан оролцуулж буй байдал, уурхайн зөрчил гомдлын мэдээлэл, усны хэрэглээ болон биологийн төрөл зүйлд нөлөөлөх байдал гэх мэт мэдээлэл багтана. Үнэлгээнд багтсан уурхайн гуравны нэг нь эдгээр асуудлын аль ч зүйлээр нь ямар нэг үйл ажиллагааны тайлан гаргаагүй байна. Олон нийтэд нээлттэй мэдээлэл хангалтгүй байгаагаас компани болон нутгийн иргэдийн хооронд харилцан итгэлцсэн харилцааг бий болгох, хамтын ашиг сонирхлоо тодорхойлж хамтрах боломж буурч байна.

6 Нэг удаагийн тохиолдлын судалгаанаас системтэй үйл ажиллагаанд шилжих шаардлага

Хамгийн сайн гүйцэтгэлийн чанартай компаниуд нь тодорхой нэг улс эсвэл тодорхой нэг уурхайд л холбогдох үйл ажиллагаанаас илүү ЭЗБОНЗ-ын асуудлыг компани даяарх нэгдсэн бодлого, үйл ажиллагаагаар зангидаж байна. Эдгээр компаниуд байгууллагын тогтолцооны түвшинд ажиллах стандарт зааврууд гаргаж, үүнийгээ бизнесийн бүхий л түвшинд хэрэгжүүлж үр дүнг нь эргэн хянаж байна. Асуудлыг тогтолцооны түвшинд авч үзсэн компаниудын үр дүн амжилттай өсөн нэмэгдэх боломжтой нь нотлогдсоор байна.

8 Нээлттэй мэдээлэл (Open data) хөгжих шатанд байна

Тайлагнасан мэдээлэл нь хэрэглэгчдэд хялбар ойлгогдож, түүнийг үнэлэх болон харьцуулахад хялбар байх нөхцөлийг хангах нээлттэй мэдээллийн зарчмыг цөөн тооны компаниуд баримталж, хэрэгжүүлж байна. Сайн туршлагыг нэвтрүүлэх нь мэдээллийг салгаж, ялгах, цаг тухайд нь мэдээлэх, өөрчлөлт гарч байгааг олж мэдэх, нөхцөл байдлыг ерөнхийд нь ойлгох, орон нутгаас хандаж мэдээлэл авч болох, машин унших боломжтой байх шаардлагуудыг хангах юм. Нийтийн ашиг сонирхолд холбогдох мэдээллийг шуурхай нийтэлснээр компаниуд нь Засгийн газар, хөрөнгө оруулагч, иргэний нийгэм гэх мэт оролцогчдын илүү сайн мэдээлэлжсэн оролцоог хангах юм.

Нийт үр дүн

Сэдэвчилсэн бүлгүүдийн үр дүн

Индексийн бүлэг тус бүрийн хувьд 30 компани харилцан адилгүй үр дүнг гаргажээ. Үр дүнгийн ялгаа нь хоёр салбарын хувьд хамгийн их байна. Эдийн засгийн хөгжил болон Уурхайн Ашиглалтын Үе Шат Удирдлага гэсэн бүлэгт нэгээс хоёр компани л бусад бүх компаниудаасаа эрс илүү сайн байна. Энэхүү ялгаа нь зарим талаар тус хоёр сэдэвт хамаарах индикаторуудын тоо цөөн мөн энэхүү асуудлуудад компаниуд хэр их анхаарал тавьж буйгаас шалтгаалж байна.

Нөгөө талаас доорх хоёр салбарын үр дүнгийн хувьд компаниуд ерөнхийдөө ижил түвшинд байна: Бизнесийн ёс зүй ба Хөдөлмөрийн нөхцөл. Компаниудын дийлэнх олонх нь эдгээр салбаруудын зарим асуудлуудад анхаарлаа хандуулж байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь ихэнх компаниуд бизнесийн ёс зүй, ажлын байранд эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилтыг дэвшүүлж, эдгээр зорилтоо хэрэгжүүлэхийн тулд бодитой алхмууд хийснээ харуулж чадаж байна.

Олон компаниуд зарим тодорхой салбарт харьцангуй сайн ажиллаж байгаа ба ажиллагаа нь ерөнхийдөө тун сайн биш асуудлын хувьд ч шилдэг туршлагыг нэвтрүүлсэн байна. Үүний зэрэгцээ компаниудад бүх бүлгүүдэд холбогдох ЭЗБОНЗ-ын асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлэх ажлаа сайжруулах бүрэн боломжтой нь илэрхий байна.


Индексийн жагсаалтын үр дүн нь нэг компанийн нийт авч болох оноонд (нийт 6 оноо) харьцуулсан үзүүлэлт төдийгүй аль нэг сэдэвчилсэн бүлгийн бүх индикаторуудын хүрээнд бүх компаниудын авсан хамгийн сайн онооны нийлбэрийг харгалзан бүлэг бүр дахь өнөөгийн шилдэг туршлагын хэмжээ хаана хүрч буйг харуулсан.

Олон компаниуд аль нэг бүлгийн хувьд сайн үр дүн гаргажээ. Иймд бүх салбарын хувьд цаашид сайжрах боломж бий гэдэг нь харагдаж байна.


Нийт үр дүн




Эдийн засгийн хөгжил




Бизнесийн ёс зүй




Уурхайн ашиглалтын үе шат удирдлага




Орон нутгийн сайн сайхан



Хөдөлмөрийн нөхцөл



Байгаль орчны хариуцлага



--- Холбогдох сэдэвчилсэн бүлгийн хувьд бүх үзүүлэлтийн хамгийн сайн оноог нэгтгэсэн байдал.

“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Нийт үр дүн

Хамгийн сайн гэж нэг компанийг онцлох боломжгүй байдал

Хамгийн сайн үзүүлэлт гаргасан арван компанийн жагсаалт нь бүлэг тус бүрийн хувьд харилцан адилгүй байна. Ерөнхийдөө 30 компанийн 19 нь багадаа нэг удаа нэг сэдэвчилсэн бүлгийн жагсаалтад багтжээ. Энэ нь компанийн гүйцэтгэлийн үр дүн нь түүний хэмжээ, олборлодог бүтээгдэхүүний төрөл, аль улсад үйл ажиллагаа явуулдаг, эсвэл аль улсад бүртгэлтэй гэдгээс хамаардаггүйг харуулж байна.

Компани нэг салбарт сайн дүн авсан нь бусад салбарт сайн дүн авна гэдгийг шууд илтгэхгүй буюу нийт үр дүнд ч шууд нөлөөлөх хүчин зүйл биш.

Өндөр оноотой компаниуд нь эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын (ЭЗБОНЗ) асуудлыг шийдвэрлэхэд системтэйгээр, компани даяарх нэгдсэн үүрэг хариуцлага, арга барилаар ажилладаг нийтлэг дүр зураг харагдаж байна. Эдгээр компаниуд ЭЗБОНЗ-ын бүх асуудлаар ижил системтэй арга барилыг нэвтрүүлж үйл ажиллагаагаа улам сайжруулах боломжтой байна.

Нэгдсэн байдлаар 30 компанийн 19 нь багадаа нэг салбарын үзүүлэлтээрээ шилдэг гүйцэтгэлтэй компанийн тоонд орсон. Энэ нь компанийн гүйцэтгэл түүний хэмжээ, олборлодог бүтээгдэхүүний төрөл, хаана үйл ажиллагаа явуулдаг, эсвэл аль улсад бүртгэлтэй гэдгээс хамаардаггүйг харуулж байна.

Бүлэг тус бүрээр хамгийн өндөр үзүүлэлттэй арван компани

Эдийн засгийн хөгжил

1	Anglo American
2	Vale
3	Newmont Mining
4	CODELCO
-	Exxaro Resources
6	Barrick Gold Corp
7	ArcelorMittal
8	Vedanta Resources
9	Antofagasta
-	Glencore
-	Rio Tinto
-	Teck Resources
-	UC RUSAL

Бизнесийн ёс зүй

1	Newmont Mining
2	BHP
3	Anglo American
4	Antofagasta
5	Goldcorp
-	Teck Resources
7	Rio Tinto
8	Glencore
9	ArcelorMittal
10	AngloGold Ashanti

Уурхайн ашиглалтын үе шат удирдлага

1	Anglo American
2	Teck Resources
3	AngloGold Ashanti
4	Newmont Mining
5	Barrick Gold Corp
-	Newcrest Mining
7	Vale
8	Goldcorp
9	Antofagasta
10	Glencore

Орон нутгийн сайн сайхан

1	Anglo American
2	Newmont Mining
3	Barrick Gold Corp
4	AngloGold Ashanti
5	Teck Resources
6	Gold Fields
7	Freeport-McMoRan
8	BHP
9	Glencore
10	Goldcorp

Хөдөлмөрийн нөхцөл

1	AngloGold Ashanti
2	Anglo American
3	CODELCO
4	Freeport-McMoRan
5	Glencore
6	Newmont Mining
7	Vale
8	Rio Tinto
9	Gold Fields
-	Teck Resources

Байгаль орчны хариуцлага

1	Newmont Mining
2	Teck Resources
3	Anglo American
4	AngloGold Ashanti
5	Glencore
6	BHP
7	Antofagasta
8	Rio Tinto
9	Barrick Gold Corp
10	Goldcorp


Эдийн засгийн хөгжил

Эдийн засгийн хөгжил хэсэгт ХУУИ нь компаниуд өөрсдийн хөрөнгө оруулалт үйл ажиллагаа нь уурхайн талбарын ойр орчноосоо илүү өргөн хүрээнд ашиг тусаа өгч байх буюу тухайн олборлолт явуулж буй улсынх нь нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд түлхэц болохуйц байдлыг баталгаажуулахаар авч буй арга хэмжээг харгалзан үзсэн. Эдийн засгийн хөгжлийн индикаторууд нь компаниуд тухайн улсын хөгжлийн бодлого төлөвлөгөөг харгалзан үзэж, уурхайн талбарт бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх замаар бүтээгдэхүүн гаргагч улсын чадамжийг дээшлүүлэх буюу улмаар эдийн засгийн бусад салбарт хэрэглэж болох ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэн түгээж байгаа эсэхийг үнэлж үздэг.


Үнэлгээний үр дүнгээс цөөн тооны компаниуд л энэ асуудлыг системтэйгээр авч үздэг нь харагдаж байна. Гурван компани (Anglo American, Vale болон Newmont Mining) нь энэ чиглэлд бусдаас онцгой ихээр тэргүүлж байна. Эдгээр компаниуд нь компанийн тогтолцооны түвшинд хөгжүүлсэн бодлого хөтөлбөрөөр тухайн улсын ханган нийлүүлэлтийн чадамжийг сайжруулах болон ур чадварын хөгжлийг хангахад анхаарч байгаа нь нийтлэг байна. Сонирхолтой нь зөвхөн Эдийн засгийн хөгжил хэсэгт хамгийн сайн арван компанид багтсан гурван компани (өөрөөр хэлбэл Exxaro Resources, UC RUSAL болон Vedanta Resources) нь “ур чадварын хөгжил” гэсэн асуудалд хамгийн сайн үзүүлэлтийг гаргажээ. Эдгээр компаниуд нь хүн амын ур чадварыг сайжруулах, уурхайн талбар байрших нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дээшлүүлэхэд системтэйгээр хандаж байгаа нь илэрч байна.

Эдийн засгийн хөгжилд холбогдох шилдэг туршлагууд нь ерөнхийдөө ур чадварыг дээшлүүлэх тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн компани болон тухайн улсад байгаа оролцогчдын хамтын түншлэлд суурилж байна. Үүний нэг жишээ нь компани засгийн газрын байгууллагуудтай түншлэн хөгжлийн санаачилгыг хамтран боловсруулах юм. Уг үйл ажиллагаа нь тухайн компанийн олборлолт явуулж буй бүх улсад бус ганц хоёр улсад л хэрэгжих нь түгээмэл байна. Олон компаниудын хувьд нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангах үндэсний хэмжээний зорилтыг бараг харгалзаж үздэггүй бололтой. Эдийн засгийн хөгжил хэсэгт илрүүлсэн үйл ажиллагааны дутагдалтай хэсэг нь компаниуд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч улс дахь ханган нийлүүлэлтийн боломжийг уурхайн талбараар хязгаарлахгүй хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааныхаа биелэлт, үр дүнг системтэйгээр хянаж үздэг талаарх нотолгоо хангалтгүй байдал юм.


Үр дүн: Эдийн засгийн хөгжил




■ Үүрэг амлалт (1 индикатор)



■ Үйлдэл (3 индикатор)



■ Үр нөлөө (1 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.




Бизнесийн ёс зүй

Бизнесийн ёс зүй: ХУУИ нь компанийн бизнесийн ёс зүй, сайн засаглалын тогтолцоо болон үйл ажиллагааны ил тод байдлыг үнэлж үзсэн. Бизнесийн ёс зүйн үзүүлэлтүүд нь бизнесийн ёс зүйг нэгж бүрд хангах, ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, ийм үйлдлийг шалгах, мэдээлэх болон гарч ирсэн аливаа ёс зүйтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байдал болон компанийн санхүүгийн болон засаглалын голлох асуудлын тухай тайлан гаргасан байдлыг үнэлдэг.

Хагасаас илүү тооны компаниуд нь жагсаалтын дээгүүр оноог авч ерөнхийдөө ижил түвшинд байсан тул Бизнесийн ёс зүйн төлөвшилтийн түвшин ойролцоо байна. Ингэснээр Бизнесийн ёс зүй нь бусад бүлгүүдтэй харьцуулбал хамгийн өндөр оноо бүхий байна. Энэ нь ихэнх компаниуд бизнесийн ёс зүй, авилгатай тэмцэх тодорхой хэмжээний үүрэг хүлээсэн байгаатай холбоотой. Хамгийн сайн үзүүлэлттэй компаниуд нь ёс зүйн асуудлаар бодлого гарган мөрдөхөөс гадна үйл ажиллагаа явуулж буй улсдаа төлж байгаа татвар болон бусад төлбөртэй холбогдох олон нийтийн эрх ашигт нийцэхүйц мэдээллийг системтэйгээр ил тод болгож байна. Мөн эдгээр компаниуд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүндээ олон талт байдал, оролцооны зарчмыг хангах дорвитой арга хэмжээ авч буйгаа нотлон харуулж байна.


Бизнесийн ёс зүйн сайн туршлагад хүйсийн тэгш эрхийг хангах зорилтот үзүүлэлт тогтоох, бизнесийн ёс зүйн талаар хүлээсэн үүргээ бодитой хэрэгжүүлэх шинэлэг арга хэрэгслүүд зэрэг багтана. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох, Засгийн газраас компаниудад олгосон гэрээ, лиценз, амлалтыг ил тод болгох нь хамгийн сул үзүүлэлттэй буюу цаашид ахиц дэвшил гаргах шаардлагатай хоёр салбар юм.

Үр дүн: Бизнесийн ёс зүй




--- Бүлэгт хамаарах бүх индикаторуудын хамгийн сайн оноог нэгтгэсэн байдал.


Үүрэг амлалт (3 индикатор)



Үйлдэл (7 индикатор)



Үр нөлөө (3 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Уурхайн ашиглалтын үе шат удирдлага


Уурхайн ашиглалтын үе шат удирдлага нь эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын (ЭЗБОНЗ) асуудлыг уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шат дахь бизнесийн шийдвэр гаргах үйл явцад харгалзаж үздэг эсэхэд анхаарлаа төвлөрүүлдэг. Уурхайн ашиглалтын үе шат удирдлага сэдэвт багтах индикаторууд нь компаниуд тухайн уурхайн үйл ажиллагаатай холбогдож эхэлсэн цагаас түүнийг зарах эсвэл хаах хүртэлх хугацаанд ЭЗБОНЗ-ийн асуудлыг ямар түвшинд харгалзан үзэж буй, уурхайн үйл ажиллагааны эхний шатнаас эхлэн уурхай хаасны дараах ажилчид, орон нутгийн иргэд болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, зохистойгоор удирдах төлөвлөгөө боловсруулсан байдлыг үнэлдэг.

30 компанийн Уурхайн ашиглалтын үе шатаа хэрхэн удирдаж буй үр дүн нь харилцан адилгүй байна. Үүнээс нэг компани (Anglo American) бусдаасаа илүү сайн үр дүн гаргасан ба тус компани нь хөрөнгө оруулалт, компани нэгдэн нийлэх, компанийг өөртөө нэгтгэх, салгах болон газрын нөхөн сэргээлт, уурхай хаасны дараах газар ашиглах боломжид холбогдох шийдвэртээ ЭЗБОНЗ-ын асуудлыг харгалзаж үзэх системийг боловсруулсан байна. Сонирхолтой нь өөр нэг компани (Newcrest Mining) нь зөвхөн Уурхайн ашиглалтын үе шатуудыг удирдах асуудлын хүрээнд хамгийн өндөр авсан байх ба энэ нь: хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа нийгэм-эдийн засаг, байгаль орчны шалгуурыг харгалзаж үздэгээс үүдэлтэй байна.

Уурхайн ашиглалтын үе шатыг хэрхэн удирдаж буй шилдэг арга туршлагууд нь ихэнхдээ уурхай хаах төлөвлөгөө болон газрын нөхөн сэргээлттэй холбоотой байна.


Уурхайн ашиглалтын үе шат удирдлагын үнэлгээний дүн нь олон компаниудад холбогдох нэлээд хэдэн асуудлаар ямар нэг арга хэмжээ авч байгаа эсэх талаар нотолгоо байхгүйг харуулж дутагдалтай талыг илэрхийлсэн байна. Хамгийн муу үзүүлэлт бүхий хоёр индикатор нь уурхайг хаах үеийн санхүүгийн баталгаагаар хангах болон түүнийг уурхайн түвшинд ил тод болгох мөн ажилчдыг олноор цомхтгох гэх мэт уурхайн үйл ажиллагаанд холбогдох томоохон өөрчлөлт гарах үед ажилчдыг зохих ёсоор бэлдэх гэх мэт компанийн үйл ажиллагааны сөрөг үр нөлөөг хянах явдал юм. Тус бүлгийн үнэлгээгээр хамгийн сайн оноо авсан гурван компанийн хувьд ч дээрхтэй холбоотой авч буй арга хэмжээгээ эргэн хянадаг эсэх талаарх нотолгоо байхгүй.

Үр дүн: Уурхайн ашиглалтын үе шат удирдлага




--- Бүлэгт хамаарах бүх индикаторуудын хамгийн сайн оноог нэгтгэсэн байдал.

■ Үүрэг амлалт (1 индикатор)



■ Үйлдэл (6 индикатор)



■ Үр нөлөө (1 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Орон нутгийн сайн сайхан


Орон нутгийн сайн сайхан хэсэгт ХУУИ нь компани уул уурхайн нөлөөллийн бүсэд оршдог орон нутгийн иргэд болон бусад гол оролцогчидтой хэрхэн харилцаж байгааг судлан үздэг. Орон нутгийн сайн сайхны үзүүлэлт нь компаниуд хүний эрхийг хүндэтгэх, иргэдийн нийгэм-эдийн засгийн үр дагаврыг үнэлэх, зохицуулах, хянах, сайжруулах болон эмэгтэйчүүд, нутгийн иргэд, гар аргаар болон бичил уурхай эрхлэгчдийг оролцуулан тухайн нутгийн олон талт оролцогчидтой зохистой харилцааг үүсгэх бодлого, тогтолцоог хэрхэн бий болгосныг үнэлдэг.

Орон нутгийн сайн сайханд холбогдох ерөнхий үзүүлэлт нь доогуур байгаа ба бусад бүлгүүдтэй харьцуулбал бага оноотой компанийн тоо хамгийн их байна. Хамгийн сайн оноо авсан гурван компани болох Anglo American, Newmont Mining болон Barrick Gold Corp нар эрсдэл болон үр дагаврыг (жишээ нь: хүний эрхийн хэрэгжилтийг хянан судлах болон нийгэм-эдийн засгийн үр дагаврын үнэлгээ хийх) тооцоолж, нутгийн иргэдтэй харилцах, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих илүү системтэй арга барилыг хөгжүүлсэн байна.

Орон нутгийн сайн сайханд холбогдох шилдэг туршлагын жишээ нь орон нутгийн бизнесийн санал санаачилгыг урамшуулан дэмжих, орон нутгаас ханган нийлүүлэлт хийх боломжийг шинэлэг байдлаар хөгжүүлэх зэрэг юм.


Компаниуд нь олон талт оролцогчдын нэг хэсэг болох хүний эрхийн төлөө тэмцэгчдэд анхаарал хандуулах асуудалд маш муу үр дүн гаргасан байна. Зарим компаниуд орон нутгийн эмэгтэйчүүдэд уурхайн үйл ажиллагаа нь хэрхэн нөлөөлж байгааг авч үзэх тогтолцоотой байгаа хэдий ч энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаагаа дүгнэх арга барилыг нэвтрүүлсэн гэсэн нотолгоо гаргасан компани байхгүй байна. 30 компанийн дийлэнх олонх нь нотолгоо гаргаж чадаагүй өөр нэг салбар нь иргэдийг нүүлгэн шилжүүлсний дараа тэдний аж амьдрал хэвийн байдалдаа эргэн орсон болон сайжирсан эсэх асуудлыг эргэн хянах систем ажиллаж байгаа эсэх асуудал юм.

Үр дүн: Орон нутгийн сайн сайхан




--- Бүлэгт хамаарах бүх индикаторуудын хамгийн сайн оноог нэгтгэсэн байдал.


Үүрэг амлалт (3 индикатор)



Үйлдэл (13 индикатор)



Үр нөлөө (7 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.



Ажиллах нөхцөл, орчин

Хөдөлмөрийн нөхцөл нь хөдөлмөрийн гэрээгээр болон хөлсөөр ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өөрийн санаа бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх болон ажилд орох, хөдөлмөрийн гэрээ байгуулах болон тушаал дэвшихэд шударгаар хандуулж байгаа эсэхийг үнэлдэг. Хөдөлмөрийн нөхцөлийн индикаторууд нь компаниуд хэрхэн эдгээр эрхийг хангаж, хөдөлмөрийн зүй бус туршлагаас татгалзаж байгааг үнэлдэг.


Хөдөлмөрийн нөхцөл нь хамгийн муу үзүүлэлт бүхий бүлэг бөгөөд хоёроос гурван цөөн тооны компани л бусдаасаа илүү эсхүл харьцангуй муу үнэлгээтэй байгаа бөгөөд 30 компаниудын дийлэнх ойролцоо оноо авсан. Энэхүү онооны ойролцоо байдал нь компаниудын ихэнх нь үүрэг амлалтын нэг индикатор буюу - хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавьж байгаатай холбоотой юм. Бараг бүх компани хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцөл бий болгох үүрэг амлалтыг албан ёсоор өгсөн; мөн ихэнх компаниуд энэ салбар дахь өөрсдийн үйл ажиллагааг хянаж, мэдээлдэг ба эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар өөрийн үйл ажиллагааг илүү сайжруулахад анхаарал тавьдаг нь харагдаж байна. Гэвч сөрөг үр дагаврын судалгаанд тэмдэглэсэн үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан тоо баримт (2015, 2016 онуудад 331 тохиолдлыг мэдээлсэн) нь энэхүү асуудалд нийтлэг анхаарч ажиллаж байна гэдэг сэтгэхүйгээс хөндийрч, нэгийг бодох ёстойг харуулж байна. Түүнчлэн олон компаниуд энэхүү хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хариуцлагаас гадна бусад хөдөлмөрийн асуудлуудыг шийдвэрлэхэд хангалтгүй арга хэмжээ авч байна гэдэг нь харагдаж байна.

Хөдөлмөрийн нөхцөл бүлэгт хамгийн сайн оноо авсан хоёр компани (AngloGold Ashanti ба Anglo American) нь албадан хөдөлмөрлүүлэх, хүүхдийн хөдөлмөр гэх мэт хөдөлмөр эрхлэлтийн муу жишигт системтэйгээр анхаарч, арга хэмжээ авч байна.


Эмэгтэй ажилчдын шаардлагыг хангах, ажиллах хүчний дотор олон талт байдлыг дэмжих, түүнийг бүрдүүлэх тусгай арга хэмжээнүүд Хөдөлмөрийн нөхцөлийн хамгийн сайн туршлагуудын жишээ юм.

Нөгөө талаас үйл ажиллагааны дутагдал хамгийн их байгаа бөгөөд компаниуд шийдвэрлэх арга хэмжээ хэрэгжүүлж байгаа талаарх баримт хамгийн хангалтгүй байгаа салбаруудад ажилчдад өгч байгаа цалин хөлс нь амьжиргааны баталгаажих түвшинд хэрхэн хүрч эсвэл илүү байгаа, ажилчдын санал гомдлыг хүлээж авч анхаарч байгаа эсэхийг хянах, ажлын байранд аливаа төрлийн ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх зэрэг хамаарч байна.


Үр дүн: Хөдөлмөрийн нөхцөл




■ Үүрэг амлалт (1 индикатор)



■ Үйлдэл (4 индикатор)



■ Үр нөлөө (3 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Байгаль орчны хариуцлага


Байгаль орчны хариуцлага нь уул уурхайтай холбоотой байгаль орчны нөлөөллийн өргөн хүрээний асуудлыг авч үздэг. Байгаль орчны хариуцлагын индикатор нь агаарын чанар, усны чанар болон хэмжээ, биологийн төрөл зүйлд гарах үр дагавар төдийгүй хүлэмжийн хий, үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээ, чичиргээнээс урьдчилан сэргийлэх, зайлуулах, багасгах болон зохицуулах асуудалд системтэйгээр хандах үүрэг хариуцлагаа компаниуд хэрхэн биелүүлж байгааг үнэлдэг.

Компаниудын байгаль орчны хариуцлагын үзүүлэлт нь бага оноо бүхий компаниас өндөр оноо бүхий компани хүртэл аажмаар өгссөн байгааг харж болно. Үйл ажиллагааныхаа үр нөлөөг эргэн хянаж буй нотолгоог ихэнх компаниуд гаргаж чадсан нэг салбар нь “Байгаль Орчны Хариуцлага” байсан бөгөөд онцгойлон хүлэмжийн хий болон эрчим хүчний хэрэглээний асуудлыг хамарч байна. Харин илүү өндөр үзүүлэлт бүхий компаниуд уурхайн хаягдлаас үүдэх эрсдэл, биологийн төрөл зүйлийн менежмент гэх мэт өөр бусад асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа эргэн хянадаг байна.

Байгаль орчны хариуцлагын сайн туршлагад уурхай орчмын агаарын чанарын хяналтын мэдээллийг шууд дамжуулах, дуу чимээ болон чичиргээг хэмжиж, үр дагаврыг багасгах шинэлэг арга хэмжээнүүд багтана.


Цаашид сайжрах боломж өндөр нэг салбар нь уурхайн орчмын гамшгаас урьдчилан сэргийлэх болон шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх санхүүгийн баталгаатай эсэх мэдээллээ олон нийтэд ил болгох явдал юм. Санхүүгийн баталгааны талаарх мэдээллийг уурхай тус бүрээр нийтэлсэн компани байгаагүйг анхаарууштай.

Үр дүн: Байгаль орчны хариуцлага




--- Бүлэгт хамаарах бүх индикаторуудын хамгийн сайн оноог нэгтгэсэн байдал.


■ Үүрэг амлалт (2 индикатор)



■ Үйлдэл (8 индикатор)



■ Үр нөлөө (6 индикатор)



“Өнөөгийн хамгийн сайн туршлага” гэсэн үнэлгээ нь нийт компанийн тухайн бүлэгт хамаарах бүх индикаторт авсан хамгийн сайн онооны нийлбэрийг илтгэнэ. 6 оноо нь авч болох хамгийн дээд оноо.

Компанид холбогдох бүх үнэлгээ нь ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан олон нийтэд нээлттэй, эсхүл компаниас өөрөөс нь өгсөн мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Уурхай тус бүрийн үнэлгээний үр дүн

ХУУИ-ийн ихэнх индикаторууд нь нийт компанийн хэмжээнд үйлчлэх бодлого, үйл ажиллагаанд хамаарах ба компанийн хариуцлагыг бүхэлд нь авч үздэг. Түүнчлэн уурхайн түвшинд хэрэглэсэн зургаан индикатор нь компанийн уул уурхайн үйл ажиллагааны мэдээллийг уурхайн талбар бүрээр нь салгаж харуулах зорилготой. Хэдийгээр компанийн ерөнхий үнэлгээний хүрээнд багтаагүй ч эдгээр уурхайн түвшний индикатор нь ажилчид, орон нутгийн иргэд, уурхай орчмын байгаль орчин болон эдийн засагт холбогдох хамгийн чухал асуудлуудыг компаниуд хэрхэн шийдвэрлэж буйг нарийвчлан судлах боломж олгоно. Мөн компани бодлого практикаа үйл ажиллагааныхаа нэгж бүрд нэгдмэл байдлаар хэрэгжүүлж байгаа эсэхийг дүгнэх юм.

Компани тус бүрээс тав хүртэлх тооны уурхайг үнэлгээнд хамруулахаар сонгосон. Эдгээр уурхайнууд нь хөгжиж буй эсхүл өсөн дэвжиж буй эдийн засагтай болон нийгмийн тэгш байдал их хэмжээгээр алдагдсан улсуудад байрлаж байна. Таваас бага тооны уурхайтай компаниудын хувьд бүх уурхайг нь сонгож авсан. 30 компанийн нийт 127 уурхай үнэлгээнд хамрагдсан.


Уурхайн түвшний индикаторууд уул уурхайн маш нарийн тодорхой үйл ажиллагааг хамардаг болохыг анхааруулах нь зүйтэй. Энэхүү индикатор тус бүрд хамруулсан зургаан сэдвийн (өөрөөр хэлбэл орон нутгаас уурхайд ханган нийлүүлэлт хийх, нутгийн иргэдийн ажил эрхлэлт, нутгийн иргэдийн санал гомдлыг хүлээн авах механизм, ажилчдын санал гомдлыг хүлээн авах механизм, усны чанар, хэмжээний менежмент, биологийн төрөл зүйлийн менежмент) хүрээнд уурхайг дараах шалгуураар дүгнэдэг:

- Дээрх асуудлаар өөрийн үйл ажиллагааг хэрхэн хянаж, мэдээлж байгаа байдал;
- Ийнхүү хянахын тулд биелүүлэх тодорхой зорилго зорилт болон гарааны цэгийг тодорхойлсон байдал;
- Үйл ажиллагааны үр дүн тасралтгүй сайжирч байгааг батлан харуулах.

Энэхүү индикаторууд нь уурхай тодорхой асуудал шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа хэрхэн хянан сайжруулж байгааг харуулах зорилготой боловч бодит байдал дээрх үр дүнг хэмжихийг зориогүй болно. Шийдвэрлэх асуудлын нөхцөл байдал өөр хоорондоо ялгаатай учир бүх уурхайг нэг ижил түвшинд шударгаар үнэлэх боломжгүй юм. Уурхайн түвшний индикаторт багтсан сэдвүүдийг ил тодоор үйл ажиллагаагаа хянах, эргэн мэдээлэх шаардлагыг компанид тавьж болохуйц байдлыг харгалзан сонгосон ба үнэлгээтэй танилцахдаа үүнийг санууштай.


Доорх зургаан хүснэгт нь 127 уурхайн оноог уурхайн-түвшний зургаан индикатор бүрээр харуулна.

Орон нутгийн ханган нийлүүлэлт




83 уурхай 0 оноотой

Орон нутгийн ажил олголт



57 уурхай 0 оноотой

Орон нутгийн иргэдийн санал гомдол



103 уурхай 0 оноотой

Ажигласан зүйлс

Уурхайн түвшний индикаторуудын үзүүлэлт өөр хоорондоо харилцан адилгүй, ихээхэн ялгаатай байна. Үнэлгээнд цугласан баримтаас дүгнэхэд уурхайн түвшний мэдээллийг тайлагнах тал дээр компани даяар хэрэгжих үр нөлөөтэй, системчилсэн арга барил бүхий компани байгаагүй бөгөөд 30 компанийн аль нь ч тухайн компанийн үнэлгээнд хамрагдсан уурхай бүрийн мэдээллийг нэгдмэл байдлаар тайлагнаагүй. Уурхайн түвшний индикаторуудын судлах бүх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа хянах болон тайлагнах тал дээр бусад уурхайтай харьцуулахад илүү үзүүлэлттэй байсан хоёр уурхай нь Оюу Толгой болон Алумбрера (Alumbrepa) нар юм. Оюу Толгой уурхайн хувьд төслийн хөрөнгө оруулагч болох “Олон Улсын Санхүүгийн Корпорац”-ийн зүгээс ил тод тайлагнах шаардлага тавьдгаас шалтгаалан өндөр үзүүлэлт гаргаснаараа нөгөө уурхайгаасаа ялгаатай байна.

Үйл ажиллагааны мэдээлэл маш хомс байгаагаараа онцгой ялгарч буй 3 индикаторт: Орон нутгийн иргэд ба Ажилчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизм, мөн Биологийн төрөл зүйлийн менежмент хамаарч байна. Эдгээр асуудлуудад холбогдох арга хэмжээнийхээ үр нөлөөг хянадаг талаарх нотолгоог ихэнх уурхай гаргаж чадаагүй ба маш олон уурхай ач холбогдолгүй мэдээлэл гаргасан бол үнэлгээнд хамрагдсан нийт уурхайн гуравны нэг нь ямар ч нотолгоо гаргаагүй. Тун цөөн тооны компани мэдээллээ уурхайн түвшинд салгаж, тусад нь тайлагнаж байна.

Уурхайн үнэлгээний үр дүнгийн тойм

Уурхайн талбарын индикатор	4 Эсвэл түүнээс дээш оноо авсан уурхайн тоо (нийт 6 оноо)*	0* Оноо авсан уурхайн тоо
Орон нутгийн ханган нийлүүлэлт	16	83
Орон нутгийн ажил эрхлэлт	11	57
Орон нутгийн санал гомдол	7	103
Ажилчдын санал гомдол	1	119
Усны чанар, хэмжээ	3	73
Биологийн төрөл зүйлийн менежмент	7	104


*Авч үзсэн бүх уурхайн тоо: 127.

Ажилчдын санал гомдол




119 уурхай 0 оноотой

Усны чанар, хэмжээ



73 уурхай 0 оноотой

Биологийн төрөл зүйлийн менежмент



104 уурхай 0 оноотой

Ажиггласан зүйлс

2018 оны ХУУИ-ийн үр дүн уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудалд хандах хандлага нь хөгжлийн янз бүрийн түвшинд байгааг харуулж байна. Энэхүү хэсэгт үйл ажиллагааны үзүүлэлт ерөнхийдөө тааруу байсан болон зарим харилцан огтлолцсон асуудлуудын цаад нөхцөл байдал, шалтгааныг тодруулах ба тэдгээрийг тогтолцооны түвшинд шийдсэнээр уул уурхайн салбар болон түүний нөлөөлөлд буй орон нутгийн аль алинд нь ашиг тустай болохыг товч тайлбарлана.

Үйл ажиллагааны нотолгоо

Баримтлах бодлого ба түүнтэй уялдах практик үйл ажиллагааныхаа талаар хэрэгцээт, ач холбогдол бүхий мэдээллийг олон нийтэд хүргэж буй зарим компаниудыг эс тооцвол ихэнх нь маш хязгаарлагдмал мэдээлэл дэлгэж байна. Нотолгоонд суурилсан үнэлгээ болохын хувьд ХУУИ-ийн үр дүн дээрх ялгаатай байдлыг илэрхийлж байгаа нь компаниудыг аливаа үйлдлийнхээ талаар мэдэгдэл хийх төдийхнөөр бус хариуцлагатай бодлого, практикийг бодитоор бий болгосноо батлахыг шаарддагтай холбоотой. Нөгөө талаас, зарим компани олон нийтэд мэдээлснээсээ илүүг хийдэг байх үндэслэлтэй бөгөөд хэрвээ компаниуд ЭЗБОНЗ-ын асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаараа илүү нээлттэй байсан бол Индексийн үнэлгээний үзүүлэлт харьцангуй өндөр байх боломжтой. Иймд илүү ил тод байдал нь сайн туршлагаас харилцан суралцаж, цаашид илүү хөгжих боломжийг нээж өгөх юм.

Эрсдэл ба үр нөлөө

Баримтлах бодлого ба түүнтэй уялдах практик үйл ажиллагааныхаа талаар хэрэгцээт, ач холбогдол бүхий мэдээллийг олон нийтэд хүргэж буй зарим компаниудыг эс тооцвол ихэнх нь маш хязгаарлагдмал мэдээлэл дэлгэж байна. Нотолгоонд суурилсан үнэлгээ болохын хувьд ХУУИ-ийн үр дүн дээрх ялгаатай байдлыг илэрхийлж байгаа нь компаниудыг аливаа үйлдлийнхээ талаар мэдэгдэл хийх төдийхнөөр бус хариуцлагатай бодлого, практикийг бодитоор бий болгосноо батлахыг шаарддагтай холбоотой. Нөгөө талаас, зарим компани олон нийтэд мэдээлснээсээ илүүг хийдэг байх үндэслэлтэй бөгөөд хэрвээ компаниуд ЭЗБОНЗ-ын асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаараа илүү нээлттэй байсан бол Индексийн үнэлгээний үзүүлэлт харьцангуй өндөр байх боломжтой. Иймд илүү ил тод байдал нь сайн туршлагаас харилцан суралцаж, цаашид илүү хөгжих боломжийг нээж өгөх юм. НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Талаар Баримтлах Зарчмууд-д нийцүүлэн үйл ажиллагаанаас нь үүсэж болох эрсдэл болон нөлөөллийг олон талт байдлаар, тогтолцооны түвшинд судалснаар тухайн компани энэ чиглэлд манлайлал үзүүлэх боломжтой.³

Үр нөлөө

Компаниуд тодорхой асуудлаар үүрэг амлалт өгсөн эсвэл ямар нэг үйлдэл хийж буйгаа харуулсан нотлох баримттай харьцуулбал тэдгээр алхмынхаа үр нөлөөг эргэн хянах тал дээр нийтдээ маш хангалтгүй нотолгоо гаргасан. Үйл ажиллагааны хяналт түгээмэл байдаг байгаль орчны асуудлын хувьд хүртэл үр нөлөөний хяналтын талаарх мэдээллийн зөрүү асар

3 Энд “Нэн чухал” гэсэн үгийг НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн талаар баримтлах үндсэн зарчмуудад хэрэглэсэн байдаг. Энэ нь зөвхөн компанийн ашиг сонирхлын үүднээс асуудал, үр нөлөөг тодорхойлоод зогсохгүй бүхий л оролцогчдын (компанийг өөрийг нь багтаана) буюу нийгмийн ашиг сонирхлыг бүхэлд нь харгалзаж үзэхийг ач холбогдолтойд тооцдог.

их байна. Жишээ нь компаниудын гуравны нэг нь биологийн төрөл зүйлийг хэрхэн зохицуулж байгаа талаар ямар нэг баримт гаргаагүй байна. ЭЗБОНЗ-ын асуудлын менежментээ илүү системтэйгээр хянаж үзэх нь компаниудад илүү сайн “ойлгох, харуулахад” - буюу өөрийн үйл ажиллагааг хэр зэрэг үр дүнтэй байгааг ойлгож, түүнийгээ бусдад харуулахад хэрэгтэй юм. Үйл ажиллагааны үр дүнгээ хянах нь тасралтгүй хөгжих чиглэлээ зөв тодорхойлоход тустай юм.

Эдийн засгийн хөгжлийн өгөгдөл

Нийт компанийн гуравны нэгээс бага хувь нь өөрийн үйл ажиллагаа шууд явагдах нутаг дэвсгэрээс гадна тухайн олборлолт явуулж буй орныхоо хөгжлийн төлөвлөгөөг харгалзаж үзэх амлалтаа батлан харуулсан. Харин зарим цөөн тооны компани үндэсний болон бүс нутгийн хөгжилд чиглэсэн стратеги төлөвлөгөөг засгийн газар, түншлэгч талууд болон бусад оролцогчидтой хамтран боловсруулж буйгаа нотолсон. Гэвч эдгээр санаачилгууд нь компани даяар нэгдмэл байдлаар бус, зөвхөн аль нэг түвшинд салангид байдлаар хэрэгжих нь түгээмэл байна. Үйлдвэрлэгч улс дахь хөгжлийн түншүүдтэй хамтарч ажиллахад хүчин чармайлт гаргах нь уул уурхайн компаниуд эдийн засгийн суурь хөгжилд хувьд нэмрээ оруулж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) хангахад дэмжлэг үзүүлэхэд тустай.

Гэрээний ил тод байдал ба ашиг хүртэгч эзэд

Ямар ч компани Засгийн газраас олгогдсон лиценз болон гэрээ хэлцлээ компанийн тогтолцооны түвшинд ил тод болгоогүй ба цөөн хэд нь өөрийн ашиг хүртэгч эздийн талаарх мэдээллийг нийтэлсэн байна. Уул уурхай нь олон орны эдийн засагт чухал нөлөө бүхий салбар болохын хувьд уг салбарт хийгдсэн гэрээ, ашгийг нь хүртэгч жинхэнэ эздийн талаарх мэдээллийг компанийн бүх түвшинд ил тод болгох нь гэрээ хэлцэл шударгаар хийгдэх, авилгаас урьдчилан сэргийлэх болон дараа дараачийн үеийн эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалж үлдэхэд хэрэгтэй.

Хүний эрх

Компаниудын дийлэнх нь хүний эрхийг дээдлэн ажиллах үүрэг амлалтынхаа талаар мэдээлсэн байх боловч зөвхөн тал хувь нь НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Талаарх Баримтлах Зарчимд нийцсэн албан ёсны үүрэг хүлээсэн байна. Цаашлаад, нийт компанийн 30% нь л хүний эрхтэй холбоотой аливаа сөрөг эрсдэлээс сэргийлэх, бууруулахад чиглэсэн хүний эрхийн үнэлгээний систем бий болгосон байна. Үүнээс ч цөөн тооны компани өөрийн үйл ажиллагаатай холбогдох хүний эрхийн нөлөөллийг хэрхэн удирдаж буйгаа нээлттэй мэдээлсэн байна. Уул уурхайн салбар нь уурхайн талбар дахь аюулгүй байдал, харуул хамгаалалттай холбоотой хүний эрхийн зөрчилтэй тогтмол тулгарч байдаг учир уг асуудалд хэрхэн нухацтай хандаж буйгаа харуулах нь тун чухал байдаг ч зөвхөн долоон компани Аюулгүй байдал ба Хүний Эрхийн Сайн Дурын Зарчмууд-ын дагуу хүний эрхийн болзошгүй зөрчлийг шийдвэрлэх арга зам боловсруулж түүнийхээ үр нөлөөг эргэн хянагдаа баталсан.

Хүний эрхийг хамгаалагчид

Зөвхөн ганц компани өөрийн үйл ажиллагаандаа хүний эрхийн төлөө тэмцэгчдийн эрхийг хүндэтгэх тодорхой үүрэг амлалт хүлээснээ нотолсон. Дэлхийн олон өнцөгт иргэний нийгмийнхэн дуу хоолойгоо гаргах боломж улам хумигдаж байгаа энэ үед уул уурхайн компаниуд хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хүндэлж үздэг гэдгээ илэрхий харуулах нь нэн чухал юм.

Санал гомдол ба хариу арга хэмжээ

Зарим нэг жишээг үл харгалзвал компаниуд ажилчид болон нутгийн иргэдийн санал гомдлыг хүлээн авч барагдуулах механизмынхаа үр нөлөөг хянан дүгнэдэг талаарх нотолгоо маш хангалтгүй байна. Санал гомдол хүлээн авч барагдуулах механизмынхаа үр нөлөөг хянадаг гэсэн баримт нотолгоог компаниуд нийтдээ гаргаж чадахгүй байгаа нь тэд уг механизмын хэрхэн ажиллаж буйг харуулах, бүр ажиллаж байгаа эсэхэд ч ач холбогдол өгөхгүй байна хэмээн ойлгож болохоор байна. Ажилчид болон орон нутгийн иргэдийн санал гомдолд хэрхэн анхаарлаа хандуулсан мөн тэдгээр санал гомдлыг хэрхэн барагдуулсан талаараа нээлттэй мэдээлэх нь оролцогчдын тус механизмд итгэх итгэлийг бэхжүүлэхэд тустай юм.

Амьжиргааны баталгаажих түвшинд хүрсэн цалин хөлс

Нэг уурхайд хийгдсэн судалгааг үл харгалзан нийт гучин компанийн аль нь ч тэдний олгож буй цалин амьжиргааны баталгаажих түвшинд хүрч эсвэл илүү гарч байгаа эсэхийг хянаж үздэг талаарх нотолгоо гаргаагүй. Цалин хөлсний хэмжээг амьжиргааны баталгаажих түвшинд нийцсэн цалингийн түвшинтэй жишин тогтоох, мөн тийм цалингийн стандартгүй улсуудад ч адил хэрэгжүүлэх нь тухайн компани ажилчдынхаа хүний эрхэм чанарыг хүндэтгэж буй хэрэг бөгөөд амьдралын суурь хэрэгцээгээ хангаж, нийгмийн амьдралд оролцох боломж олгож буй хэрэг юм. Амьжиргааны өртөгт нийцсэнээс илүү цалин олгож байгаа хэмээн мэдэгдсэн компаниудын хувьд ч бодит байдал дээр тэр нь батлагдсан эсэх нотолгоо байхгүй байна.

Эмэгтэйчүүд

Үйл ажиллагаандаа жендерийн асуудлыг системтэйгээр авч үзэхээ баталгаажуулсан компани маш цөөн ба жишээ татахад, нийт компанийн 20% нь л эмэгтэй ажилчдаа хүчирхийлэл, бэлгийн дарамтаас хамгаалах нэгдсэн арга хэмжээ авч байна. Уурхайн нөлөөлөлд буй орон нутгийн хувьд ч компанийн зүгээс жендерийн асуудлаар явуулах арга хэмжээ дутмаг байгаа ба жишээ нь орон нутагтай холбоотой үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн аль аль нь орон нутгийн бизнес хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд хамрагдахад тусламж үзүүлэх зэрэг ажиллагаа шаардлагатай байна. Үйл ажиллагааных нь улмаас эмэгтэйчүүдэд учирч буй нөлөөллийг шийдвэрлэх арга хэмжээ нь ямар үр дүнтэй байгааг хянадаг ямар ч компани байхгүй байна. Иймд ажлын байранд болон үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн эмэгтэйчүүдэд тулгарч буй уул уурхайн нөлөөллийг зохицуулах арга хэлбэртээ дүгнэлт хийн сайжруулах нь эмэгтэйчүүдэд учирч буй ноцтой эрсдэл, давуу бус байдлыг оновчтойгоор шийдвэрлэхэд дөхөм болно.

Залуус

Хэрэгжүүлж буй орон нутгийн бизнес эрхлэлтийг дэмжих болон ур чадвар хөгжүүлэх төсөл санаачилгууддаа уурхайн нөлөөллийн бүс дэх залуусын оролцоог баталгаажуулах тодорхой нөхцөл бүрдүүлсэн компанийн тоо маш цөөн байна. Түүнчлэн орон нутагтай харилцахдаа залуусыг хамруулах талаар тусгайлан хүчин чармайлт гаргаж буйгаа нийт компанийн 10% нь нотолсон байна. Залуустай идэвхтэй харилцах, тэднийг шийдвэр гаргах эрх мэдэлтэй болгох нь компаниудад ихэнхдээ орхигддог тэдний хэрэгцээ болон хэтийн хүсэл тэмүүллийг нь ойлгож мэдэх боломж болох ба улмаар уурхайн нөлөөлөлд орших орон нутгийн ирээдүйн сайн сайхан, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тустай.

Хүүхэд

Өөрийн үйл ажиллагааныхаа хүүхдэд үзүүлэх нөлөөллийг онцгойлон үнэлдэг компани байгаагүй бөгөөд зөвхөн 35% нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн эрсдэлийн үнэлгээ ба уг эрсдэл тулгарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх тогтолцоотой холбоотой нотолгоо гаргасан. Хүүхдэд уул уурхай ямар эрсдэл, нөлөөлөл үзүүлж буйг судлан үнэлэх болон шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах нь компаниуд уурхайн нөлөөлөлд өртдөг уг хамгийн эмзэг нийгмийн бүлгийг хамгаалахад ач холбогдолтой.

Уугуул иргэд

Уугуул иргэдэд хамаарах тусгай эрх буюу аливаа эрдэс баялгийн төсөл эхлэхээс өмнө чөлөөтэйгөөр, мэдээллээр урьдчилан хангагдсаны үндсэн дээр зөвшөөрөх эрхийг хүндэтгэх тодорхой үүрэг амлалт хүлээсэн зарим компани байгаа ч нийт компанийн гуравны нэгээс бага хувь нь уугуул иргэдийн эрх ашиг, сонирхлыг хүндэтгэж үзэх төлөвлөгөөг системтэйгээр боловсруулсан байна. Уугуул иргэдтэй зөвлөлдөхөөс гадна тэдний зөвшөөрлийг чөлөөтэй, урьдчилсан мэдээллээр хангасны үндсэн дээр авах нь компаниуд тэдний эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх ажлыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх суурь болно.

Бичил уурхай (БУ)

Нийт 30 компанийн 8 нь бичил уурхай тэдэнд хамааралтай асуудал биш хэмээн мэдэгдсэн бол зөвхөн 6 компани бичил уурхайтай ойр байрладаг уурхайн талбар дахь үйл ажиллагаандаа БУ эрхлэгчид болон орон нутгийн иргэдтэй харилцах стратеги төлөвлөгөөг системтэйгээр хөгжүүлж байна. Харин цөөн тооны компани БУ эрхлэгчдэд техникийн туслалцаа үзүүлэх болон БУ-аас өөр төрлийн амьжиргааны хэрэгсэлтэй болоход нь дэмжлэг үзүүлэх системтэй байна. БУ-тай хэрхэн холбогдох талаар системчилсэн үр дүнтэй арга зам хэрэгжүүлснээр компаниуд БУ эрхлэгчид болон орон нутгийн иргэд илүү аюулгүй бөгөөд тогтвортой амьжиргааны хэрэгслээр хангагдахад хувь нэмэр болох юм.

Уурхайн хаалтын дараах амьдрах чадвар

Уурхай хаагдсаны дараах орон нутгийн иргэд болон ажилчдын амьдрах чадварт анхаарлаа хандуулж буй нотолгоо маш бага олдсон бөгөөд нийт компанийн зөвхөн гуравны нэг нь л уурхайн хаалтын дараах орон нутгийн иргэдэд зориулсан шилжилтийн төлөвлөгөөг боловсруулсан бол мөн тооны компани ажилчдад зориулсан шилжилтийн ойролцоо системтэй байна. Уурхайн нөлөөлөлд өртсөн эдгээр оролцогчидтой хамтарсан төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлэх нь компаниуд уурхай хаагдсаны дараах тогтвортой ирээдүйг баталгаажуулах хийгээд эерэг уламжлал үлдээхэд тустай байдаг байна.

Санамж

Хариуцлагатай уул уурхайн 2018 оны индексэд тусгагдсан ололт, дүгнэлт, тайлбарууд нь Хариуцлагатай уул уурхайн сангийн нийт ажилчид, хэлэлцүүлэгт оролцсон болон тайланд зөвлөсөн бусад этгээдүүдийн итгэл үнэмшлийг илтгээгүй болно.

Энэхүү тайлан нь хэлбэр, агуулгын түвшинд зар сурталчилгааны зорилгогүй, гагцхүү мэдээллийн чанартай болно. Энэхүү тайлан нь нягтлан бодох бүртгэл, хууль, татвар, хөрөнгө оруулалтын аливаа зөвлөгөө өгөх, мөн аливаа худалдааны зорилгогүй болно. Хариуцлагатай уул уурхайн индекс 2018-ын үнэлэх аргын талаар судлах тохиолдолд цахим хуудсанд хандана уу.

ХУИ нь компаниудын эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудалд хандах бодит үр дүнг судлахгүйгээр түүний бодлого, туршлагыг нотлох нотолгоонд суурилдаг билээ. Үнэлгээ нь гагцхүү олон нийтэд ил тод мэдээлэлд суурилсан. Хэдийгээр энэхүү мэдээлэл нь найдвартай гэж үзэх боломжтой ч үүнийг үнэн зөв, бүрэн гэдэгт ямарваа нэгэн баталгаа гаргах боломжгүй бөгөөд ХУИ нь энэхүү байдлыг харгалзан үзэж чадаагүй болно. Үүнээс үзвэл компаниудаас мэдээллээ ил тод болгодоггүй байдал, мэдээлэл олж авахад тодорхой саад байдаг гэх мэт шалтгаанаас муу үнэлгээ авсан компаниудыг дан ганц бодлого, туршлага муутай хэмээн дүгнэсэн нь өрөөсгөл байх магадлалтай.

Энэхүү индекс-д хамруулсан бүх компаниудыг үнэлгээний үндэслэл болсон холбогдох мэдээллийн эх сурвалжтай танилцах, компанийнхаа мэдээллийг нягтлах тухай урьсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Хэдийгээр орчуулгын нийцлийг шалгах арга хэмжээ авагдсан боловч Англи хэлтэй хувилбарыг тодорхойлох хувилбар гэж үзнэ. ХУИ нь өөрийн цахим хуудсанд зассан хувилбарыг нийтлэх эрхийг хадгалах боловч уншигчид та бүхэнд тулгарсан ойлгомжгүй, зөвтгөх асуудал байвал цахим хуудсанд хандана уу.
www.responsibleminingindex.org

Зохиогчийн эрх

Бүх өгөгдөл, бичгэн контентууд нь Creative Commons Attribution-NonCommercial 4.0 International License (CC BY-NC 4.0) дагуу хамгаалагдсан. Хэрэглэгчид нь бусдад түгээх эрхтэй боловч зохих ёсоор ишлэл авч, хэрэв өөрчлөгдсөн тохиолдолд дээрх зөвшөөрлийн цахим хуудсыг багтаах ёстой. Энэхүү материалыг худалдааны зорилгоор болон ялгаварлан гадуурхал, доромжлол, гүтгэх агуулгаар ашиглах ёсгүй. Ишлэх тохиолдолд: “Хариуцлагатай Уул Уурхайн Индекс 2018 (ХУИ), Хариуцлагатай Уул Уурхайн Сан(ХУУС).” гэх. Тусгайлан дурдсанаас бусад тохиолдолд ХУИ болон ХУУС-ын цахим хуудсанд байрласан зураг, фото зураг, дүрс бичлэг дээрх хамгаалалтад ороогүй болно.



<https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

responsibleminingindex.org

